


СОНГУУЛИЙН МАЖОРИТАР ТОЙРГИЙН МАНДАТЫГ ЗОХИСТОЙ ТОГТООХ НЬ



ННА 66
ДАА 320
О-417

ISBN 978-9919-529-09-3



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

СОНГУУЛИЙН МАЖОРИТАР ТОЙРГИЙН МАНДАТЫГ ЗОХИСТОЙ ТОГТООХ НЬ

Агора Институт
Д.Оргил

I. Оршил.....	5
II. Судалгааны үндэслэл, хүрээ, арга зүй, хүлээгдэж буй үр дүн	6
III. Сонгуулийн тойрог байгуулахад анхаарах асуудал.....	8
Ричард Ниеми нарын дэвшүүлсэн шалгуур үзүүлэлт	8
Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн гаргасан зөвлөмж	9
Хорасио Бониогийн тоймлосон шалгуур үзүүлэлт	10
Нэг хүн, нэг санал, нэг үнэ цэн зарчим	11
Сонгуулийн тойрог байгуулахтай холбоотой олон улсын эрх зүйн зохицуулалт	11
Монгол Улсын сонгуулийн тойрог байгуулах эрх зүйн зохицуулалт	13
IV. Саналын зохисгүй төлөөлөл (malapportionment).....	16
Монгол Улсын сонгууль дахь саналын зохисгүй төлөөлөл	17
V. Сонгуулийн тойргийг боловсронгуй болгох санал	19
А. Багц саналын тогтолцоо	19
Б. Бүсчилсэн тойрог (томсгосон багц саналын тогтолцоо)	22
В. Нэг мандаттай тойрог (ялагч бүхнийг авах тогтолцоо).....	24
VI. Дүгнэлт	27
Зөвлөмж	29
Ашигласан материалын жагсаалт	30
Хавсралтууд.....	31

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулиуд (тойрог байгуулах зохицуулалт).....	14
Хүснэгт 2. Тойрог, суудал, сонгогчийн тоо, саналын зохисгүй төлөөлөл (malapportionment) 1992-2024.....	17
Хүснэгт 3. Санал болгож буй сонгуулийн тойрог, хүн ам, мандатын тоо.....	19
Хүснэгт 4. Бүсчилсэн сонгуулийн тойрог дахин ашиглах нөхцөлд санал болгож буй мандатын тооны зохист харьцаа	22
Хүснэгт 5. Нэг мандаттай сонгуулийн тойрог ашиглах нөхцөлд санал болгож буй 78 тойрог.....	25

Дүрсийн жагсаалт

Дүрс 1. Саналын зохисгүй төлөөлөл (malapportionment) хувиар 1992-2024 ...	17
Дүрс 2. Нэг мандатад ногдох сонгогчдын тоо УБ, Орон нутаг 1992-2024.....	18
Дүрс 3. Сонгуулийн тойрог, мандат санал болгож буй хувилбар.....	21
Дүрс 4. Санал болгож буй хувилбар, УБ хот дахь сонгуулийн тойрог, мандат.....	21
Дүрс 5. Бүсчилсэн сонгуулийн тойрог дахин ашиглах нөхцөлд санал болгож буй мандатын тооны зохист харьцаа	23
Дүрс 6. Санал болгож буй хувилбар, УБ хот дахь сонгуулийн тойрог, мандат.....	24

I. Оршил

Монгол Улс ардчилсан Үндсэн хуулиа баталсан 1992 оноос хойш УИХ-ын ээлжит сонгуулийг 9 удаа зохион байгуулахдаа сонгуулийн тогтолцоог нийт найман удаа өөрчилжээ. Тодруулбал, 1992, 1996, 2005, 2011, 2015, 2016, 2019 онд тус тус сонгуулийн хуулийг шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах замаар сонгуулийн тогтолцоог өөрчилсөөр ирсэн бол 2023 онд Үндсэн хуульд тусгасан. Үүнтэй холбоотойгоор сонгуулийн тогтолцоо хэт ойрхон өөрчлөгдөж байна гэх шүүмж тасралтгүй гардаг байлаа. Монгол Улс харьцангуй олонхын тогтолцоог (FPTP) 1996, 2000, 2004 болон 2016 онд, багц саналын тогтолцоог (Block Vote) 1992, 2008, 2020 онд, холимог тогтолцоог (parallel) 2012, 2024 онд тус тус хэрэглэжээ. 2023 онд Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог тусгаснаар сонгуулийн тогтолцоо байнга өөрчлөгдөх эрсдэлийг багасгасан хэдий ч сонгуулийн тойргийг сонгууль бүрийн өмнө эрх баригч намын үзэмжээр шийдвэрлэх эрсдэл хуульд хадгалагдан үлдсэн юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт, “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” гэжээ. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө сонгуулийн тойрог байгуулна” гэж тойрог байгуулах эрхийг УИХ-д олгосон.

2024 оны сонгуульд Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийг нийт 2-10 мандаттай 13 тойрог болгон хуваасан бөгөөд 13 тойргоос 78 гишүүнийг сонгосон. Сонгуулийн тойрог байгуулахдаа хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан үзэхээр хуульд заасан боловч сонгуулийн тойргууд хүн ам, нутаг дэвсгэрийн хувьд хэт зөрүүтэй байсан нь ардчилсан сонгуулийн “нэг санал, нэг үнэ цэн” зарчимтай зөрчилдсөн. Тодруулбал, сонгуулийн 13 тойргоос 11-т нь сонгогчдын тоо сонгогчдын дундаж тооноос хамгийн багадаа 15 хувиар хэтэрсэн бол, Улаанбаатар хотын 4 тойрогт 50 хувиар хэтэрчээ. Энэ зөрүүтэй байдал нь сонгуулийн тойргоос үл хамааран саналын үнэ цэн ижил тэгш байхад сөрөг нөлөөлж, олон улсын сайн туршлагад нийцэхгүй байна (Сонгууль ажиглах хорооны эцсийн тайлан, 2024, хууд. 8). Мөн, 2024 оны УИХ-ын сонгуулиар нийслэлд нэг мандатад ногдох сонгогчдын дундаж тоо 41,068 байсан бол орон нутагт 20,451 байсан нь (Монгол Улсын Их Хурлын сонгууль 2024, Ерөнхий тойм, 2024, хууд. 4) ардчилсан

сонгуулийн тэгш эрхийн зарчимд үл нийцнэ. Иймээс, “нэг санал, нэг үнэ цэн” зарчмыг хангасан сонгуулийн тойрог байгуулах, сонгуулийн тойргийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, сонгууль бүрийн өмнө тойрог шинээр байгуулдаг байдлаас салах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

II. Судалгааны үндэслэл, хүрээ, арга зүй, хүлээгдэж буй үр дүн

Хүний иргэний болон улс төрийн эрх, сонгох, сонгогдох эрх, ардчилсан сонгуулийн зарчим, ардчилсан сонгууль зохион байгуулахад баримтлах хэм хэмжээ зэрэг нь судлагдаагүй шинэ сэдэв биш бөгөөд энэ талаар олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан байдаг. Тодруулбал, 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт, Европын хүний эрхийн конвенц, Европын Аюулгүй байдал Хамтын ажиллагааны байгууллагын Копенхагены баримт бичиг зэрэгт сонгох, сонгогдох суурь зарчмуудыг тусгасан. Харин Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс гаргасан судалгааны бүтээл, гарын авлагууд, Европын Аюулгүй байдал Хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, Хүний эрхийн газраас гаргасан судалгааны бүтээл, зөвлөмжүүд, сонгууль ажиглалтын тайлангууд болон Венецийн комиссоор хэлэлцэгдсэн асуудлуудад сонгуулийн тойрог хэрхэн байгуулах, ямар шалгуур үзүүлэлт ашиглах зарчим, зөвлөмжүүдийг агуулдаг.

Энэхүү судалгааны ажилд Монгол Улсын Их хурлын сонгуулийн тойрог байгуулах арга нь олон улсын ардчилсан сонгуулийн зарчимд нийцэж буй эсэх, хэрхэн нийцүүлэх, сонгуулийн тойргийг нэг санал нэг үнэ цэн зарчимд нийцсэн байдлаар хэрхэн байгуулах, ингэхдээ сонгуулийн хуульд тусгасан зарчмуудыг хэрхэн нийцүүлэх зэрэг асуудлыг судлах болно.

Монгол Улсын Их Хурал 1992-2024 оныг хүртэл нэг танхимтай, 76 гишүүнтэй байсаар ирсэн. 76 гишүүнийг 1996, 2000, 2004, 2016 онд нэг мандаттай 76 тойргоос, 1992, 2008 онд 2-4 мандаттай 26 тойргоос, 2012 онд мажоритар сонгуульд 50 гишүүнийг 26 тойргоос, 2020 онд 2-5 мандаттай 29 тойргоос тус тус сонгосон. Харин 2024 онд Үндсэн хууль, сонгуулийн эрх зүйн орчинд Улсын Их Хурлын 126 гишүүний 78 гишүүнийг 2-10 мандаттай 13 тойргоос сонгосон ч 11 тойрогт сонгогчдын тоо олон улсын ардчилсан сонгуулийн зарчимд нийцэхүйц дундаж сонгогчдын тооноос хэтэрсэн байна. Энэ нь дан ганц 2024 оны сонгуулиар илэрсэн гажуудал биш бөгөөд 1992-2024 оны хооронд болсон бүх сонгуульд саналын зохисгүй төлөөлөл ихэссээр ирлээ. Үүнийг дараагийн хэсгүүдэд дэлгэрүүлж авч үзэх болно. 2024 онд хууль, эрх зүйн шинэ орчинд УИХ-ын сонгуулиа зохион байгуулсан ч,

сонгуулийн тойрог байгуулах асуудлыг олон улсын жишиг, ардчилсан сонгуулийн зарчимд цаашид нийцүүлэхийн тулд энэ оны сонгуулиар асуудлыг нарийвчлан судалж, шаардлагатай зөвлөмж боловсруулж, хуульд өөрчлөлт оруулах асуудал чухлаар тавигдаж байна.

Сонгуулийн тогтолцоо хэрхэн өөрчлөгдөж байгаа нь сонгууль институтийнхээ хувьд төлөвшихөд сөрөг нөлөөтэй, мөн мажоритар сонгуулийн тогтолцоог байнга хэрэглэснээр Монгол Улсын нэгдсэн бодлогод сөрөг нөлөөлж, жалганы улс төрчдийг төрүүлж байна, мөн сонгогчдын санал ихээр гээгдэж байна гэх мэт шалтгаанаар сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульд суулгаж өгсөн. Европын Аюулгүй байдал, Хамтын ажиллагааны байгууллагын 1990 оны Копенхагены баримт бичгийн 7.3 дахь догол мөрд төр улсууд насанд хүрсэн иргэддээ сонгох эрх олгохыг шаарддаг (Document of the Copenhagen Meeting of the Conference on the Human Dimension of the OSCE, 1990). Венецийн комиссын 2002 оны Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын эмхэтгэлийн 2.2-д парламентын суудал хуваарилах сонгуулийн тойргийг ижил хуваах ёстой бөгөөд зөвшөөрөгдөх зөрүү нь сонгогчдын 10 хувиас, онцгой тохиолдолд (үндэсний цөөнхийн болон хүн ам цөөн суурьшсан алслагдсан нутгийн төлөөллийг хангах гэх мэт) 15 хувиас хэтрэхгүй байхыг зөвлөжээ (Code of Good Practice in Electoral Matters, 2002). Мөн 2023 оны Куала Лумпурын тунхаглалд ч сонгуулийн тойрог байгуулахтай холбоотой эрхэмлэн үзэх зарчмуудыг агуулсан (Kuala Lumpur Declaration on Apportionment and Boundary Delimitation, 2023).

Тус судалгааны ажлын хүрээнд дээрх зарчмыг баримтлан дараах арга зүйгээр судалгааны ажлыг гүйцэтгэнэ.

- Тоон судалгааны арга зүй – Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан өмнөх сонгуулиудын албан ёсны дүнг ашиглан 1992-2024 оны сонгуулийн тойргууд дээрх зарчимд хэрхэн нийцсээр ирснийг тооцоолно.
- Бодлогын сонголтын хувилбар санал болгох – нэгдүгээр хэсэгт хийсэн тооцоолол, хоёрдугаар хэсэгт гарсан сайн туршлага дээр үндэслэн Монгол Улсын Их Хурлын 78 гишүүнийг нэг сонгогч, нэг үнэ цэн зарчимд нийцүүлэн хэдэн тойргоос сонгож болох талаар бодлогын сонголтын хувилбар боловсруулна. Ингэхдээ харьцангуй олонхын болон багц саналын сонгуулийн тогтолцоо гэх хоёр үндсэн хувилбарыг ашиглана. Багц саналын сонгуулийн тогтолцооны үед хэдэн мандаттай хэдэн тойрог байгуулж болох хувилбарыг дэвшүүлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд:
 - Хүн амын тоо,
 - Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь
 - Газар нутгийн хэмжээ, байршил
 - Саналын зохистой төлөөлөгдөх байдал
 - Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

Судалгааны ажлын эцэст Улсын Их Хурлын сонгуулийн тойргийг а) 78 гишүүнийг 78 тойргоос сонгох, б) 78 гишүүнийг багц саналаар сонгох тохиолдол тус бүрд ардчилсан сонгуулийн зарчмуудыг хадгалан сонгуулийн тойрог байгуулж болох бодлогын хувилбарууд дэвшүүлнэ. Эдгээр бодлогын хувилбарууд олон улсын сайн туршлага, Монголын сонгуулийн түүх, сургамжийг харгалзан үзнэ.

III. Сонгуулийн тойрог байгуулахад анхаарах асуудал

Administration and Cost of Elections Project (ACE project) төслийн мэдээллийн санд дурдсанаар, дэлхийн улс орнуудын гуравны хоёр орчим нь сонгуулийн тойргийг тусад нь байгуулдаг бол, гуравны нэг орчим нь улсынхаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн шууд сонгуулийн тойрог болгон ашигладаг байна (Karjalainen, 2007). Мөн тус төслийн мэдээллийн санд, улс орнуудын 34.4 хувь нь сонгуулийн тойрог байгуулах эрх мэдэл парламентад хадгалагддаг бол, 19.4 хувьд нь бие даасан хороонд хадгалагддаг талаар дурджээ. Учир нь сонгуулийн тойрог байгуулах эрх мэдэлтнүүд үргэлж өөрийн ялах боломжийг хадгалахыг эрмэлзэх тул хараат бус хороонд тойрог байгуулах эрх мэдэл олгох хандлага ажиглагдаж байна. Монгол Улсын хувьд сонгуулийн тойрог байгуулах эрх УИХ-д хадгалагдсаар ирсэн. УИХ-ын сонгуулийн тойрог байгуулах асуудал сонгуулийн хууль тогтоомжид хэрхэн зохицуулагдсаар ирснийг дараагийн бүлэгт өгүүлнэ.

Улс төрийн ашиг сонирхлыг сонгуулийн тойрог байгуулах үйл явцаас ангид байлгах асуудлыг судлаачид, олон улсын байгууллагууд онцгойлон авч үзсээр ирсэн. Энэ хэсэгт сонгуулийн тойргийг хэрхэн байгуулах, сонгуулийн тойрог байгуулахад анхаарах зарчим зэргийн талаар судлаачдын дэвшүүлсэн хувилбаруудыг тоймлов.

Ричард Ниemi нарын дэвшүүлсэн шалгуур үзүүлэлт

Дэлхийн улс орнууд сонгуулиар хууль тогтоох байгууллагын төлөөлөгчдийг сонгохдоо заавал сонгуулийн тойргийн зохион байгуулалт ашигладаг. Сонгуулийн тогтолцооноос хамааран тойргийн тоо, хэмжээ, хэлбэр, харилцан адилгүй байж болох ч сонгуулийн тойроггүйгээр сонгууль зохион байгуулах боломжгүй юм. Тухайлбал, Цэвэр хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоог хэрэглэсэн тохиолдолд ч улс бүхэлдээ нэг тойрог болох, эсвэл нутаг дэвсгэрийг хэд хэдэн тойрогт хувааж санал хураалт явуулна. Сонгуулийн тойрог нь тухайн тойргоос хэдэн төлөөлөгч сонгож буйгаас хамааран нэг мандаттай, олон мандаттай гэж ангилагдана. Тухайлбал, 2024 оны УИХ-ын сонгуульд хувь тэнцүүлсэн өрсөлдөөнд улс нэг тойрог болж 48 төлөөлөгчийг, харин олонх дийлэнхийн өрсөлдөөнд олон мандаттай 13 тойргоос 78 гишүүнийг сонгосон билээ.

Сонгуулийн тойргийг бүх улс төрийн нам, нэр дэвшигчдэд ижил тэнцүү ашигтай байхаар байгуулах бараг боломжгүй. Залуус төвлөрсөн, ахмадууд төвлөрсөн, намын дэмжлэг угаас сайтай газар илүү олон суудал хуваарилсан шинжтэй тойрог байгуулах нь мэдээж залуусын, ахмадын, дэмжлэг сайтай тэдгээр намуудад ашигтай. Сонгуулийн тойрог байгуулахад тойргууд жигд хэмжээтэй, хил залгаа байхаас гадна хэд хэдэн шинж чанарыг агуулсан байх ёстой. Тиймээс сонгуулийн идеал тойрог байгуулах зарим арга, хэрэгслийг судлаачид дэвшүүлжээ. Тухайлбал, Ричард Ниemi, Жон Дийган нар сонгуулийн тойрог байгуулахад төвийг сахисан байдал (neutrality), мэдрэмжийн цар хүрээ (range of responsiveness), хөвөгч саналын харьцаа (constant swing ratio), өрсөлдөх чадвар (competitiveness) зэргийг тооцож үзэх талаар тодорхойлжээ (Niemi & John, 1978). Энд төвийг сахисан байдал гэдэгт аль ч улс төрийн нам сонгогдох ижил боломжийн талаар, мэдрэмжийн цар хүрээ гэдэгт нэг намаас нөгөө намд шилжих суудлын өөрчлөлт нь нийт саналын хэдэн хувьд хэлбэлзэж буй хүрээ, хөвөгч саналын харьцаа гэдэг нь намын авсан санал нэг нэгжээр өсөхөд суудал хэрхэн өөрчлөгдөх харьцааг, харин өрсөлдөх чадвар гэдэгт намын хатуу дэмжигчдийн хувь нь тойргийн нийт сонгогчдын 50 хувиас бага байх тойргийн хувийг хэлнэ (Niemi & John, 1978). Товчхондоо, Ричард Ниemi, Жон Дийган нар сонгуулийн идеал тойрог байгуулахад:

- Төвийг сахисан байдал
- Мэдрэмжийн цар хүрээ
- Хөвөгч саналын харьцаа
- Өрсөлдөх чадвар зэрэг шалгуурыг дэвшүүлжээ.

Ардчилал сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн гаргасан зөвлөмж

Ардчилал сонгууль дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс гаргасан Олон Улсын Сонгуулийн Стандарт: Сонгуулийн эрх зүйн цар хүрээг дахин авч үзэх зааварчилгаанд (International IDEA, 2001) тойрог байгуулахад дараах хүчин зүйлсийг нэн тэргүүнд харгалзан үзвэл зохино гэжээ. Үүнд:

- Төлөөлөл
- Саналын хүч ижил тэгш байх
- Талуудад ижил ашигтай буюу алагчлалгүй байх гэсэн үндсэн гурван зарчмыг нэрлэжээ.

Төлөөлөл

Сонгогчид нь өөрсдийгөө бүрэн төлөөлж чадах нэр дэвшигчийг сонгох боломжийг олгосон байдлаар сонгуулийн тойрог зурагдах ёстой. Өөрөөр хэлбэл, сонгогчид хамтын сонирхлыг аль болох төлөөлөх нэр дэвшигчийг сонгох бололцоогоор илэрхийлэгдэнэ. Хамтын сонирхол гэдэгт засаг захиргааны нэгж, угсаатан ястан, газар зүйн байршил гэх

мэт олон хувилбараар илэрнэ. Хэрэв эдгээр сонирхол хангагдахгүй бол тойргийг бүтэн төлөөлөх нэгж нэр дэвшигч байх боломжгүй болно.

Саналын хүч ижил тэгш байх

Сонгогчийн санал сонгуулийн аль тойрогт харьяалагдаж байгаагаас үл хамааран саналын хүч ижил тэгш байх ёстой. Бодит байдалд аливаа улс сонгуулийн тойргийг яг тэнцүү хэмжээний сонгогчидтой байдлаар хуваарилан байгуулах боломжгүй хэдий ч саналын үнэ цэн аль болох ойролцоо байхыг эрхэмлэх ёстой. Сонгогчийн санал тойрогт тэнцүү хуваарилагдсан (apportioned), санал тэнцүү хуваарилагдаагүй (malapportioned) гэх ойлголт бий. Санал хамгийн төгс хуваарилагдсан тогтолцоонд нэг ч иргэний санал нөгөөгийнхөөс илүү жин дарах учиргүй. Тухайлбал, Израйл Улсын парламентад (Knesset) 120 гишүүнийг нэгдмэл нэг тойргоос сонгодог бөгөөд сонгогч бүрийн санал ижил жинтэй. Мөн Нидерланд, Перу, Намиб болон Сьерра Леон зэрэг улсууд парламентын доод танхимыг улс бүхэлдээ нэг тойрог бүхий хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгох тул сонгогчдын санал яг ижил үнэ цэнтэй байна (Samuels & Snyder, 2001).

Талуудад ижил ашигтай буюу алагчлалгүй байх

Сонгуулийн тойргийг хэн зурж буй нь бус хэрхэн зурж, байгуулж буй нь илүү чухал байх зарчим. Өөрөөр хэлбэл, сонгуулийн тойрог байгуулахад улс төрийн үзэмжээр бус бичигдсэн хуулийн дагуу байгуулах нь зүйтэй. Сонгуулийн тойрог байгуулах үйл явц улс төрийн намын оролцоогүй байх, улс төрийн нам оролцох ёстой гэвэл бүх намын төлөөлөл ижил тэгш оролцох ёстой. Хууль тогтоох байгууллага сонгуулийн тойрог байгуулахад чухал үүрэгтэй оролцох тохиолдолд олонх болсон нам илүү давуу эрхтэй оролцож таарна. Энэ тохиолдолд тойрог байгуулах үйл явц маш тодорхой, бусад гол намууд бүрэн ойлгож, хүлээн зөвшөөрч байж сонгуулийн тойрог байгуулагдах ёстой.

Хорасио Бониогийн тоймлосон шалгуур үзүүлэлт

Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага, Европын холбоо гэх мэт олон улсын байгууллагын урт хугацааны сонгууль ажиглах арга зүй, болон Хамтын нөхөрлөлийн орнууд, Картерын төв (Carter Center), Ардчиллын төв (Center for Democracy) зэрэг богино хугацаанд сонгууль ажиглах үйл явцад ажиглагдсан хандлагуудад үндэслэн Хорасио Бонио сонгуулийн тойрог байгуулахад дараах шалгуур үзүүлэлтүүд тавигдаж буйг тоймложээ. Үүнд:

1. Хүн амын болон сонгогчдын тоо – бараг бүх улс оронд ашиглаж буй үндсэн шалгуур үзүүлэлт. (нэг санал – нэг үнэ цэн зарчим)
2. Газар зүйн байршил – хавцал, арал, гол мөрөн зэрэг газар зүйн хүчин зүйлсийг харгалзан үзэх
3. Засаг захиргааны нэгж – засаг захиргааны нэгж, зарим

тохиолдолд овгийн болон уугуул иргэдийн оршин суудаг засаг захиргааны нэгжийг тойрог байгуулахад харгалзах

4. Оршин суугчдын сонирхлын нийтлэг байдал – төлөөллийг хангахын тулд оршин суугчдын нийтлэг сонирхлыг харгалзан тойрог байгуулах
5. Сонгуулийн тойрог байгуулах уламжлал – Хамгийн тэргүүлэх ач холбогдолтой шалгуур үзүүлэлт биш боловч, улс орнууд тойрог байгуулахдаа харгалзан үзэж буй хандлага (Boneo, n.d.)

Нэг хүн, нэг санал, нэг үнэ цэн зарчим

Нэг хүн, нэг санал, нэг үнэ цэн (one person, one vote, one value) зарчим нь тойргийн хүн амын ялгаа болон сонгогчийн хэн байхаас үл хамааран иргэн бүрийн санал сонгуулийн үр дүнд ижил жинтэй байх ёстойг илэрхийлсэн ардчиллын суурь зарчим юм. Энэхүү зарчим нь сонгогчийн оршин суугаа газар, тойргийн хүн амын ялгаа, эсхүл хувь хүний бусад шинж байдлаас үл хамааран улс төрийн тэгш байдлыг бодитоор хангахыг шаарддаг. Иймд уг зарчим нь зөвхөн санал өгөх эрхийн тэгш байдлыг төдийгүй төлөөллийн шударга, ардчилсан тогтолцоог хангах үндсэн шалгуур болдог.

Нэг хүн, нэг санал, нэг үнэ цэн зарчим алдагдвал улс саналын зохисгүй төлөөлөл үүсэж, улс төрийн эрх тэгш бус байдал үүсэх шалтгаан болдог. Тухайлбал, 2016 оны сонгуулийн 34-р тойрогт (Ховд аймаг) сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэлтэй 14002 сонгогч байсан бол, 63-р тойрогт (Чингэлтэй, Налайх) 41271 сонгогч ногдож байлаа. Өөрөөр хэлбэл, 34-р тойргийн сонгогчийн саналын үнэ цэн, 63-р тойргийн сонгогчийн саналын үнэ цэнээс 3 дахин их байна гэсэн үг юм.

Сонгуулийн тойрог байгуулахтай холбоотой олон улсын эрх зүйн зохицуулалт

Сонгуулийн тойрог бол сонгуулийн ажлын зохион байгуулалтын гол хэлбэр мөн (Б.Чимид, 2008, хууд. 69). Хэдийгээр сонгуулийн тойрог байгуулах нь зохион байгуулалтын шинжтэй боловч Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт болон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн баримт бичигт туссан сонгох, сонгогдох эрхтэй нийцэж байх нь зүйтэй. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 21-р зүйлд “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно” (The Universal Declaration of Human Rights, 1948) гэсэн бол Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 25 (b) -д Иргэн бүр “Сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй

илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох” (United Nations, 1967) эрх эдэлнэ гэжээ.

Хүний эрхийн суурь баримт бичгүүдэд сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан бол, 1990 оны Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллагын (ЕАБХАБ)-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар (АИХЭГ)-ын Копенхагений баримт бичиг, 2002 оны Венецийн комиссоос гаргасан Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын эмхэтгэл (Code of good practice in electoral matters), 2023 оны Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн, Цэвэр, шударга сонгуулийн эвсэл, Тиндак Малайз болон Индонезийн Ардчилал, сонгуулийн холбооны гаргасан Куала Лумпурын тунхаглал зэрэг баримт бичгүүдэд сонгуулийн тойрог байгуулахад харгалзах зарчмуудыг тодорхойлжээ. Тухайлбал,

- ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Копенхагений баримт бичгийн 7.3-т
 - “Оролцогч талууд . . . насанд хүрсэн иргэдийн бүх нийтийн, тэнцвэртэй сонгуулийн эрхийг баталгаажуулна”
- Венецийн комиссын “Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын эмхэтгэл”-ийн
 - 2.1 “Саналын тэнцүү хүч: Зарчмын хувьд сонгогч бүр нэг саналын эрхтэй, сонгуулийн тогтолцоо нь нэгээс олон санал өгөх эрх олгосон бол сонгогч бүр ижил тооны саналын эрхтэй байна”
 - 2.2. ii “Тойрог бүрд ногдох суудлыг хүн амын тоо, байнга оршин суугаа хүн амын тоо (үндэсний цөөнхийг оруулаад), бүртгэлтэй сонгогчдын тоо, магадгүй бодитоо санал өгч буй хүмүүсийн тоо зэрэг шалгуурын аль нэгд үндэслэн тэнцвэртэй хуваарилна.
 - 2.2. iii “газар зүйн болон засаг захиргааны нэгжийн, эсвэл түүхэн болон хилийн хүчин зүйлсийг харгалзан үзэж болно”
 - 2.2. iv “Нормоос хүлцэх зөрүү нь 10 хувиас, онцгой тохиолдолд (цөөнхийн эрхийг хамгаалах, хүн ам сийрэг засаг захиргааны нэгжийн төлөөлөл хангах) 15 хувиас хэтэрч үл болно”
 - 2.2. v “Саналын тэнцүү жинг хангахын тулд суудал хуваарилалтыг хамгийн багадаа 10 жил тутамд, болж өгвөл сонгуулийн бус үед дахин авч үзнэ” гэж зохицуулжээ.
- 2023 оны Куала Лумпурын тунхаглалын 1-р зүйлд
 - 1.a. “Нэг хүн, нэг санал, нэг үнэ цэн зарчимд нийцүүлэн сонгуулийн бүх тойрогт байх сонгогчдын/оршин суугчдын тоо нь дунджаас 10 хувиас хэтрэхгүй байна”
 - 1.b. “Мужийн, аймгийн гэх мэт засаг захиргааны нэгжид илүү төлөөллийг гагцхүү хоёр танхимтай хууль тогтоох байгууллагын дээд танхимаар хязгаарлах бөгөөд засгийн газар байгуулдаг, хоёр танхимтай хууль тогтоох байгууллагын доод танхимд, эсвэл нэг танхимтай парламентад зөвшөөрч болохгүй”.

- 1.с. “Хөдөөгийн болон далайгаас алслагдсан газар нутагт илүү төлөөлөл олгохыг зөвтгөж болохгүй. Хэрэв хүртээмж багатай тойргуудад хүрч ажиллахад бэрхшээлтэй, хөдөөгийн сул байдлыг харгалзан үзэж буй бол нөөц хуваарилах замаар шийдвэрлэгдэх ёстой”.
- 2003 оны ЕАБХАБ-ын оролцогч улсуудын ардчилсан сонгуулийн талаарх хүлээсэн үүрэг амлалтын 3-р зүйлд
 - 3.2. “Сонгуулийн тойргийг тогтоохдоо саналын эрх тэгш байдлыг хангаж тойрог бүрд ногдох сонгогчдын тоо болон сонгогдож буй төлөөлөгчдийн тооны харьцаа ойролцоо байх ёстой. Засаг захиргааны нэгж болон бусад холбогдох хүчин зүйлс (түүхэн, хүн амзүйн, газарзүйн шинж чанартай хүчин зүйлс) нь тойрог байгуулахад тусгагдаж болох хэдий ч энэ нь саналын эрх тэгш байдал болон нийгмийн янз бүрийн бүлгүүдийн шударга төлөөллийн зарчимтай нийцсэн байх шаардлагатай.”
 - 3.3 “Шаардлагатай тохиолдолд сонгуулийн тойргийг дахин хуваарилах үйл явц нь хуулиар тогтоосон, урьдчилан таамаглах боломжтой хугацааны хуваарийн дагуу явагдах бөгөөд найдвартай хүн амын тооллого эсвэл сонгогчдын бүртгэлийн тоон мэдээлэлд үндэслэсэн байх ёстой. Тойрог шинэчлэх үйл ажиллагааг сонгуулиас хангалттай хугацааны өмнө хийж, ил тод санал, төсөлд тулгуурлан боловсруулж, олон нийтийн мэдээлэл авах болон оролцоог хангах боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Эндээс үзэхэд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, болон олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, тунхаг бичигт сонгуулийн тойрог байгуулахад дараах шаардлагуудыг чухалчилжээ.

1. Хүн амын тоо: сонгуулийн тойрогт сонгогчдын тоо дундаж сонгогчдын тооноос 10 хувиас илүү зөрүүгүй байх, онцгой тохиолдолд 15 хувиас илүү зөрүүгүй байх
2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, бусад хүчин зүйлс
3. Сонгуулийн тойрог шинэчлэн байгуулахад хүн амын тооллогыг харгалзан хамгийн багадаа 10 жил тутамд шинэчилж байх

Монгол Улсын сонгуулийн тойрог байгуулах эрх зүйн зохицуулалт

Монгол Улс ардчилсан үндсэн хууль баталсан 1992 оноос хойш 9 удаагийн УИХ-ын сонгууль болж өнгөрсөн. Сонгуулийн тойргийг хэн, хэзээ, юуг харгалзан хэний саналд үндэслэн байгуулдаг талаарх сонгуулийн хуулиудын зохицуулалтыг хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулиуд (тойрог байгуулах зохицуулалт)

	1992	2005	2011	2015	2019
Хэн байгуулах	УИХ	УИХ	УИХ	УИХ	УИХ
Хэзээ байгуулах	70 хоногийн өмнө	6 сарын өмнө	6 сарын өмнө	45 хоног	сонгуулийн жилийн 2-р сарын 1-ээс өмнө
Юуг харгалзах	Хүн амын тоо	Хүн амын тоо	Хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь	сонгуулийн тогтолцоо, хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь	Хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил
Юуг үндэслэх		СЕХ-ны санал			
Хүн амын тоог аймаг, нийслэлд ялгавартай тооцох эсэх		Тийм	Тийм		
Тойрог өөрчлөх		Хүн амын тоо өмнөх сонгуулиас 20 хувиар өөрчлөгдсөн бол	Хүн амын тоо өмнөх сонгуулиас 20 хувиар өөрчлөгдсөн бол		
Бусад	хүн амын тоо дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумдыг нэгтгэх	хүн амын тоо дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумдыг нэгтгэх	хүн амын тоо дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сумдыг нэгтгэх		Засаг захиргааны нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл, хилийн цэсийн хувьд зэргэлдээ
Шинэлэг заалт					Дараагийн ээлжит сонгууль хүртэл өөрчлөхийг хориглоно

Хүснэгт 1-ээс үзэхэд:

- Сонгуулийн тойрог байгуулах эрх 1992 оноос хойш бүх сонгуульд УИХ-д хадгалагдсаар иржээ.
- Сонгуулийн тойргийг 1992-2004 оны сонгуулиудад сонгууль болохоос 70-аас доошгүй хоногийн өмнө байгуулах хуулийн зохицуулалттай байсан бол 2008-2012 оны сонгуульд сонгууль болохоос 6 сараас доошгүй хоногийн өмнө байгуулахаар зохицуулж байв. 2016 оны сонгууль болохоос өмнө дахин 45 хоногийн өмнө байгуулахаар өөрчлөлт оров. Одоогийн хуульд сонгуулийн жилийн 2-р сарын 1-ний дотор буюу дунджаар 4 сар хагасын өмнө байгуулахаар зохицуулагдаж байна.
- Сонгуулийн бүх хуульд тойрог байгуулахад УИХ өөрөө шийддэг байсан бол 2005 оны сонгуулийн хуульд Сонгуулийн Ерөнхий Хорооны саналыг үндэслэн УИХ шийдвэрлэхээр зохицуулалт тусжээ.

- 1992-2008 оны сонгуульд тойрог байгуулахад хүн амын тоог үндэслэн байгуулна гэсэн бол, 2012 оноос хойш хүн амын тооноос гадна, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршлыг харгалзан үзэхээр зохицуулсан байна.
- 2005 оны сонгуулийн хуульд Аймаг, нийслэлд хүн амын тоог ялгаатай тооцно гэх зохицуулалт орж ирсэн нь 2011 онд хадгалагджээ. 2015 оноос хойш сонгуулийн хуулиудад энэ зохицуулалт тусаагүй хэдий ч бодит байдалд аймаг, нийслэлийн хүн амын ялгавартай тооцогдож буюу нэг сонгогч, нэг үнэ цэний зарчим алдагдсаар иржээ.
- 2005, 2011 оны сонгуулийн хуульд хүн амын тоо өмнөх сонгуулийн үеэс 20-оос дээш хувиар өөрчлөгдсөн бол тойргийг өөрчлөх талаар харгалзан үзэх талаар тусгажээ.
- Хүн амын тоо дунджаас цөөн байвал зэргэлдээ аймаг, сумдыг нэгтгэх талаарх зохицуулалт бүх хуульд туссаар ирсэн. Тухайлбал, Говьсүмбэр аймаг дангаар тойрог болж байсангүй, Дундговь, эсвэл Дорноговь аймагтай хамтатган тойрог болгосоор ирсэн байна.
- 2019 онд батлагдсан сонгуулийн хуульд засаг захиргааны нэгжийн хувьд нэгдмэл, хилийн цэсийн хувьд зэргэлдээ байна гэсэн заалт оржээ. Энэ нь 2016 оны сонгуульд Сүхбаатар дүүргийг Багануур дүүрэгтэй, Чингэлтэй дүүргийг Налайх дүүрэгтэй, Увс аймгийн хил залгаа бус, өөр хоорондоо хол зайтай орших сумдыг нийлүүлэн нэг тойрог болгон байгуулж gerrymandering¹ хийсэнтэй холбоотой юм.
- 2019 оны хуульд буюу одоо хүчин төгөлдөр үйлчилж буй сонгуулийн хуулийн нэг онцлог заалт нь дараагийн сонгууль болтол сонгуулийн тойрог өөрчилж болохгүй гэсэн заалт байна. Өөрөөр хэлбэл, 2024 оны сонгуулийн тойрог олон улсын стандартад нийцэхгүй, сонгогчдын санал зохистой төлөөлөгдөөгүй байсан ч гэсэн, сонгуулийн хуульд өөрчлөлт оруулахгүйгээр тойргийг өөрчлөх аргагүй юм.

Сонгуулийн бүх хууль, түүний нэмэлт өөрчлөлтүүдэд сонгуулийн тойрог байгуулахад хүн амын тоог харгалзан үзнэ гэх зохицуулалт туссаар ирсэн байна. Бодит байдалд хүн амын тоог харгалзан үзсэн эсэхийг шалгахын тулд тооцоолол хийх шаардлагатай. Дараах хэсэгт сонгогчдын санал зохистой төлөөлөгдсөн эсэх дээр тооцоолол хийж үзлээ.

¹ Өөртөө улс төрийн давуу байдал олох зорилгоор сонгуулийн тойргийг өөрчилж буй үйлдэл.

IV. Саналын зохисгүй төлөөлөл (malapportionment)

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, олон улсын байгууллагаас гаргасан зарчим, тунхаглал, зөвлөмж гэх мэт бодлогын баримт бичигт бүгдэд нь заавал тусгагдсан нэг чухал зарчим нь “нэг хүн, нэг санал, ижил үнэ цэн” гэх зарчим юм. Энэ зарчим хангагдвал сонгогч бүрийн санал ижил үнэ цэнтэй, хэрэв хангагдахгүй бол зарим сонгогчийн санал илүү үнэ цэнтэй болдог.

Саналын буруу төлөөлөгдөх байдал буюу malapportionment-д нэг сонгогчийн санал, нөгөө сонгогчийнхоос үнэ цэний хувьд өөр байхыг илэрхийлдэг ойлголт. Санал бүрэн төлөөлөгдөх буюу apportioned тогтолцоонд сонгогч бүрийн санал ижил тэнцүү жин дардаг бол malapportioned буюу санал буруу төлөөлөгдсөн тогтолцоонд нэг сонгогчийн саналын үнэ цэн нөгөөгийнхөөс илүү эсвэл дутуу жин дарна гэсэн үг. Хамгийн туйлширсан жишээг хийсвэрлэн авч үзвэл, саналын буруу хуваарилалт бүхий тогтолцоонд нэг хүний санал парламент дахь суудал болж, нөгөө талд бусад бүх хүний саналыг авсан нэр дэвшигч суудал авахгүй байх боломжтой гэсэн үг. Бодит амьдралд ардчилсан сонгуулийн тогтолцоо ийм туйлшралд хүргэхгүй боловч, бараг бүх сонгуулийн тогтолцоонд саналын зохисгүй хуваарилалт их, бага хэмжээгээр оршиж байдаг.

Саналын зохисгүй хуваарилалтыг судлаачид тооцоолох хэд хэдэн арга дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, Таагепара, Шугарт (Taagepera & Shugart, 1989) нар дараах томъёог дэвшүүлжээ.

$$MAL = (1/2) \sum |s_i - v_i|$$

Энд i = сонгуулийн тойрог s_i = i тойрогт ногдсон суудлын хувь, v_i = тойрогт ногдох сонгогчдын эсвэл хүн амын хувь болно. Өөрөөр хэлбэл, сонгуулийн тойрог бүрд ногдох суудлын хувь, сонгогчдын хувийн зөрүүний нийлбэрийг хоёрт хуваахад гарах тоо нь нийт сонгогчдын хэдэн хувийн санал зохисгүй хуваарилагдсаныг илэрхийлнэ. Жишээлбэл,

	Сонгуулийн тойрог				
	1	2	3	4	5
Сонгогчдын хувь	50	30	20	7	3
Суудлын хувь	40	20	20	15	5

Энэ тохиолдолд саналын зохисгүй хуваарилалт нь,

$MAL = (1/2)(|50-40|+|30-20|+|20-20|+|15-7|+|5-3|)=15$ хувь болно. Өөрөөр хэлбэл, нийт сонгогчдын 10 хувийн санал нь зохисгүй төлөөлөгдсөн гэсэн үг.

Монгол Улсын сонгууль дахь саналын зохисгүй төлөөлөл

Энэ томъёогоор 1992 оноос хойших сонгуулийн үр дүнг тооцоолж үзэв. Сонгуулийн Ерөнхий хорооны нээлттэй мэдээллийн сангаас авсан 1992-2024 оны хооронд болсон 9 удаагийн сонгуулийн тойрог, мандат, тойрогт харгалзах сонгогчдын тоон мэдээллийг ашиглан тооцоолов. Хүснэгт 2-т 9 удаагийн сонгуулийн тойргийн тоо, тойрогт ногдох мандат, сонгогчдын тоо болон саналын зохисгүй төлөөллийн тооцооллыг харуулав.

Хүснэгт 2. Тойрог, суудал, сонгогчийн тоо, саналын зохисгүй төлөөлөл (malapportionment) 1992-2024

	Тойрог	Суудал	Сонгогч	Саналын зохисгүй хуваарилалтын хувь
1992	26	76	1,060,730	4.75
1996	76	76	1,147,268	5.2
2000	76	76	1,246,749	6.8
2004	76	76	1,330,776	10.5
2008	26	76	1,542,905	13.05
2012	26	48	1,834,338	15.4
2016	76	76	1,911,047	11
2020	29	76	2,003,969	13.9
2024	13	78	2,224,233	18.2

Эх сурвалж: СЕХ-ны нээлттэй өгөгдлийн сан, зохиогчийн тооцоолол

Хүснэгт 2-оос үзэхэд 1992-2020 оны хооронд сонгогчдын тоо бараг 2 дахин нэмэгджээ. (Сонгууль бүрээр гаргасан саналын зохисгүй төлөөллийн дэлгэрэнгүй тооцооллыг хавсралтаас үзнэ үү.) Сонгууль бүрээр тойрог байгуулахдаа хүн амын тоог оновчтой харгалзан үзээгүйгээс болж саналын зохисгүй хувь 2024 онд 1992 оныхоос бараг 4 дахин нэмэгджээ. Дүрс 1-д саналын зохисгүй хуваарилалтын хувийн өөрчлөлтийг харууллаа.


Дүрс 1. Саналын зохисгүй төлөөлөл (malapportionment) хувиар 1992-2024



Эх сурвалж: СЕХ-ны нээлттэй өгөгдлийн сан, зохиогчийн тооцоолол

Дүрс 1-ээс үзэхэд 1992-2000 оны хооронд буюу анхны гурван сонгуульд саналын зохисгүй төлөөлөл 10 хувиас бага байсан бол сонгууль бүрээр нэмэгдсээр 2024 онд 20 хувь руу дөхжээ. Энэ нь 1992-2000 оны хооронд хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн харьцангуй бага байж, улмаар 2000-аад оны эхээр хотжих хөдөлгөөн эрчимжсэнтэй холбоотой байна. Улаанбаатар хотын болон аймгуудын сонгогчид хэрхэн өөрчлөгдсөнийг дараах дүрсээр харуулав.

Дүрс 2. Нэг мандатад ногдох сонгогчдын тоо УБ, Орон нутаг 1992-2024



Эх сурвалж: СЕХ-ны нээлттэй өгөгдлийн сан, зохиогчийн тооцоолол

Дүрс 2-оос үзэхэд хотын сонгогчдын тоо нэмэгдсээр ирсэн хэдий ч, хотын сонгогчдод ногдох мандатын тоо түүнтэй ижил нэмэгдсэнгүй. Эхний гурван сонгуульд Улаанбаатар хотын болон орон нутагт ногдох сонгогчдын тоо, тойргийн мандат ойролцоо байсан боловч, 2004 оноос хойших сонгуульд тойрог байгуулахдаа хүн амын тоог харгалзан мандат хуваарилсан зүйл ажиглагдахгүй байна. 1992 онд Улаанбаатарт 20 мандат, орон нутагт 56 мандат ногдож байсан бол 2024 онд 24, 54 болж үл ялиг өөрчлөгджээ. Энэ хооронд Улаанбаатар хотын сонгогчдын тоо 358 хувиар, орон нутгийн сонгогчдын тоо 150 хувиар өссөн хэдий ч Улаанбаатар хот болон орон нутагт ногдох мандатын тоо бараг ижил хэвээр байна.

V. Сонгуулийн тойргийг боловсронгуй болгох санал

Өмнөх хэсэгт Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог, сонгогчдын тоонд үндэслэн саналын зохисгүй төлөөллийн талаар тооцоолол хийж үзлээ. Сонгуулиас сонгуулийн хооронд “нэг сонгогч нэг үнэ цэн” зарчим алдагдсаар ирсэн, цаашид ч нэмэгдэх хандлагатай байгаа нь харагдаж байна. 2023 онд орсон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр УИХ-ын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох холимог сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульд тусгасан билээ. Энэ хэсэгт саналын зохисгүй төлөөллийг хамгийн бага түвшинд байлгахад сонгуулийн тойрог, мандатын тоог хэрхэн шинэчлэх талаарх бодлогын хувилбар санал болгоно. Ингэхдээ Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн Сонгуулийн тойрог байгуулах аппликейшн (Electoral Redistricting App) ашиглан тооцоолов. Тус аппликейшн нь олон улсын ардчилсан сонгуулийн зарчим, шилдэг туршлагад нийцсэн сонгуулийн тойрог байгуулах үйл явцыг дэмжих зорилготой, түгээмэл хэрэглэгдэх боломжтой газар зүйн мэдээллийн системд (GIS) суурилсан технологийн арга хэрэгсэл юм.

Тус аппликейшн ашиглаад а) 1992, 2008, 2020 онд ашигласан багц саналын тогтолцоо, б) 2024 онд ашигласан бүсчилсэн буюу илүү томсгосон багц саналын тогтолцоо в) 1996-2004, 2016 онд ашигласан ялагч бүхнийг авна гэсэн хувилбараар тооцоолол хийж сонгуулийн тойргийг санал болгож байна.

A. Багц саналын тогтолцоо

2024 оны Үндэсний статистикийн хорооны мэдээллээр Монгол Улсын 3,375,609 хүн амыг төлөөлөх 78 мандатыг аймаг, нийслэлээр ангилан дараах тойрог болон мандатыг санал болгож байна.

Хүснэгт 3. Санал болгож буй сонгуулийн тойрог, хүн ам, мандатын тоо


Дугаар	Тойрог	Хүн амын тоо	Тойрогт ногдох суудлын квот	Тойрогт ногдох суудал
1	Архангай	95276	2.27	2
2	Баян-Өлгий	103003	2.45	2
3	Баянхонгор	88834	2.11	2
4	Дархан	101059	2.4	5
	Сэлэнгэ	105852	2.52	
5	Дорноговь	64870	1.54	2
	Говьсүмбэр	18177	0.43	
6	Дорнод	78069	1.86	2
7	Дундговь	45746	1.09	1
8	Говь-Алтай	56908	1.35	1
9	Хэнтий	74263	1.77	2
10	Ховд	88738	2.11	2

